Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# СҮХБААТАР АЙМГИЙН НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН 2025 ОНЫ I УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлсэн байна. Алсын хараа 2050 -2.1. | | | | | | | |
| **Зорилт 1.1.** Боловсролын салбарын болон Насан туршийн суралцахуйн боловсролын талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд мэдээлэх, хэрэгжүүлэх; | | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн дундаж | 95% | 96% | Боловсролын салбарын болон Насан туршийн суралцахуйн боловсролын талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд мэдээлэх, хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 4 арга хэмжээний хүрээнд төлөвлөн 16 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 3941 хүнд танхим болон цахим хэлбэрээр хүрсэн. | 65 |
| 1 | **Арга хэмжээ № 1.1.1.** "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | Төсөв шаардагдахгүй | Гүйцэтгэлийн үнэлгээгээр | 94% | 94% | Аймгийн Засаг даргын 2024 оны хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 92.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдэж Тэргүүн байр эзэлж БАТЛАМЖ мөнгөн шагналаар шагнуулсан.<br><br>Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очиртой болон Аймгийн Засаг дарга М.Идэрбаттай 2025 оны үр дүнгийн гэрээгээ байгуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилт 36 арга хэмжээний хүрээнд батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээнд 2025 оны 1-р улиралд https://sukhbaatar.igovernment.mn/law/ сайтад:<br><br>• ЗГ-ын тогтоол - 3<br>• ЗГ-ын хуралдааны тэмдэглэл – 3 нийт 6 зүйл заалтыг 100 хувь тайлагнаад байна. | |
| 2 | Арга хэмжээ № 1.1.2. shilen.gov.mn/auth/signin сайтын хэрэгжилтийг тайлагнах; | Төсөв шаардагдахгүй | Гүйцэтгэлийн үнэлгээгээр | 93.5% | 95% | shilen.gov.mn сайтын хэрэгжилтийг 2025 оны 1-р улиралд:<br><br>• Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 97.45%<br>• Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 95.83%<br>• Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 75%<br>• Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал - 75%<br>• Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал – 100% үнэлгдээд явж байна. | 92,78% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Арга хэмжээ №1.1.3 Байгууллагын Нийгмийн сүлжээний хаяг болон http://su-ncle.com/ цахим хуудсаар Боловсролын салбарын болон насан туршийн суралцахуйн үйл ажиллагаанд мөрдөх хууль, журам, дүрэм, эрх зүйн баримт бичгийн талаарх мэдээллийг ил тод нээлттэй хүргэх, хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах; | Төсөв шаардагдахгүй | Мэдээллийн тоо<br><br>Мэдээлэл хүрсэн иргэдийн тоо | 150<br><br>12000 | 160<br><br>13000 | Байгууллагын http//su-ncle.com/ вебсайт, "Сүхбаатар аймгийн Насан туршийн боловсрол төв" пэйж хуудас, НТБ-ын нэгжийн цахим хуудсуудаар салбарын бодлого, үйл ажиллагаа түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээлэл – 10, зурагт хуудас - 34, үйл ажиллагааны мэдээлэл – 46, богино хэмжээний бичлэг, рийл - 4 нийт 94 мэдээллийг түгээсэн байна. Цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагааны мэдээллийг цахим болон танхимаар давхардсан тоогоор нийт 3941 иргэнд хүргэсэн. | 100 |
| | Арга хэмжээ № 1.1.4. Насан туршийн суралцахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөн туслах, арга зүйн удирдлагаар хангах ажлыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллах | Батлагдсан төсвийн хүрээнд | Танхимаар болон цахим хэлбэрээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн тоо | Танхим - 4<br>Цахим-8 | Танхим - 5<br>Цахим - 8 | НТСТ-ийн зөвлөн туслах баг Мөнххаан, Дарьганга 2 сумын нэгжид очиж танхимаар зөвлөн тусалж хамтран ажилласан.<br><br>Боловсролын ерөнхий газар, Мэдлэ сургуультай хамтран зохион байгуулж буй цахим сургалтад Сүхбаатар аймгийн нийт НТС төв, нэгжийн 20 багш, ажилтан албан хаагчдыг хамруулж байна.<br><br>13 сумын нэгжийн багш нарт цахим хэлбэрээр 5 удаа ажлын чиглэл өгч ажиллан хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг тооцон ажиллаж байна. | 70 |
| Зорилт 1.2 Байгууллагын удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, үр дүнг тайлагнах, ил тод байдал, шилэн дансны бүртгэлийн хөтлөлт, үнэн зөв байдлыг хангах; | | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээ тус бүрийн дундаж хувь | 100% | 100% | Байгууллагын удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, үр дүнг тайлагнах, ил тод байдал, шилэн дансны бүртгэлийн хөтлөлт, үнэн зөв байдлыг хангах зорилтын хүрээнд 4 арга хэмжээ төлөвлөж 6 үйл ажиллагаа хэрэгжүүлсэн. | 75 |
| 5 | Арга хэмжээ № 1.2.1. | Төсөв | Гүйцэтгэлийн | 70% | 90% | Шилэн дансанд 1-р улирлын | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын https://shilendans.gov.mn/ цахим хуудсаар иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод байх мэдээллийг түргэн шуурхай хүргэх; | шаардагдахгүй | хувь | | | байдлаар 42 мэдээллийг гаргах ёстой. Үүнээс мэдээллэсэн 38 хүлээгдэж байгаа 4 мэдээлэл байна.<br><br>Орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системд байгууллагат бүртгэлтэй эд хөрөнгийн тоолж зургийг баталгаажуулан оруулж байна. Мөн Орон нутгийн өмчийн газраас 4,7 сая төгрөгийн үнэ бүхий грашийг хүлээн авсан. | |
| 6 | Арга хэмжээ № 1.2.2 Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг хангах; | Төсөв шаардагдахгүй | Төлөвлөгөө-ний биелэлтийн хувь | 2% | 2% | Байгууллагын үйл ажиллагаанд дотоод, хяналт шалгалт хийх төлөвлөгөөг гарган ажиллаж байна. | 70 |
| 7 | Арга хэмжээ № 1.2.3. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу бүрдүүлэх, улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Төлөвлөгөө-ний биелэлтийн хувь | 70% | 80% | • Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.<br>• Байгууллагын албан хаагчдаас гарах хадгаламжийн нэгжийг үүсгэх чиглэл өгсөн.<br>• 2024 оны архивын хадгаламжийн нэгжийн боловсруулж байна.<br>• Байгууллагат гарч байгаа тушаал, албан тоот бүгд монгол бичгээр хавсралттай гарч байна. | 50 |
| 8 | Арга хэмжээ № 1.2.4. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах нээлттэй тогтолцоог бүрдүүлэх, ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэх зөрчлийн тоог бууруулах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Өргөдөл гомдлын шийдвэрлэлт-ийн хувь | 100% | 100% | 2025 оны 1-р улиралд ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэж тайланг Аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлсэн. | 100 |
| Зорилт 1.3. Төрөөс | | Батлагдсан | Арга хэмжээ | 98% | 98% | Төрөөс хэрэгжүүлж буй үндэсний | 75ы |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлж буй үндэсний болон бусад хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах, сум нэгжийн түвшинд арга зүйн удирдлагаар хангах; | төсвийн хүрээнд | тус бүрийн дундаж хувь | | | болон бусад хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд 4 арга хэмжээ төлөвлөн 5 үйл ажиллагаа зохион байгуулж 134 иргэнд хүрч ажилласан. | |
| 9 | Арга хэмжээ № 1.3.1 "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр- III"-ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, салбарын хэмжээнд хамтран хэрэгжүүлэх; | Батлагдсан төсвийн хүрээнд | Сургалтын тоо<br>Хамрагдсан төрийн албан хаагчийн тоо | 18<br><br>380 | 20<br><br>400 | Хилийн 0184-р ангийн 6-р застав Наран сумын НТС нэгжээс монгол бичгийн анхан шатны сургалтыг 3 удаа зохион байгуулж 14 албан хаагч хамруулж байна.<br><br>“Кимо хөрвүүлэгч ашиглан зурагт хуудас бэлтгэх” сургалтыг 3 аж ахуй нэгж, албан байгууллагат зохион байгуулж 42 иргэн хамрагдсан.<br><br>Насан туршийн суралцахуйн төвийн 8 албан хаагчид үндэсний бичгээ бие даан суралцаж байна. | 80 |
| 10 | Арга хэмжээ № 1.3.2. Иргэд төрийн албан хаагчдад угийн бичиг хөтлөх сургалт үйл ажиллагаа зохион байгуулах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Сургалтын тоо<br>Хамрагдсан иргэдийн тоо | 45<br><br>500 | 50<br><br>600 | “Угийн бичиг хөтлөх арга зүй” сэдэвт сургалт мэдээллийг ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 10 дугаар ангийн 70 суралцагчдад Баруун урт сумын насан туршийн нэгжээс зохион байгуулсан. | 70 |
| 11 | Арга хэмжээ № 1.3.3 "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр" -ийн хэрэгжилтийг хангах ажлыг салбарын болон байгууллагын хэмжээнд зохион байгуулах; | Төсөв шаардагдахгүй | Гүйцэтгэлийн үнэлгээгээр | - | 95 | Насан туршийн суралцахуйн төвийн 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт, 7 арга хэмжээний хүрээнд боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:<br><br>- Насан туршийн суралцахуйн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байхыг уриалсан агуулга бүхий зурагт хуудсыг 13 сумын нэгжээр дамжуулан 12 төрлийг бэлтгэн олны хүртээл болгон ажиллав. | 75 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Давхардсан тоогоор 2300 гаруй иргэнд хүргэсэн.<br>- АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын болон сум орон нутгийн насан туршийн суралцахуйн цахим хуудас, нийгмийн сүлжээний хаяг, мэдээллийн самбарт байршуулах зэрэг бүхий хэлбэрээр олон нийтэд тогтмол хүргэн ажиллаж байна. | |
| 12 | Арга хэмжээ № 1.3.4 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд сургалт сурталчилгаа хийх, мод тарих, арчлах, ургуулах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Гүйцэтгэлийн үнэлгээгээр | 100% | 100% | Хугацаа болоогүй. | - |
| Стратеги зорилго 2. Бүх насны иргэдийг албан, албан бус боловсрол, амьдралын орчинд суралцах эрх тэгш боломжийг бүрдүүлэх, боловсрол, сургалтын нээлттэй, уян хатан, орон зай, цаг хугацаанаас үл хамаарах цахим системийг, контентын санг үе шаттай нэвтрүүлэх - Алсын хараа-2050 Зорилт 2.1, ЗГҮХ-2.2.4.3, ЗДҮАХ-2.2.3.3, ЗДҮАХ-2.2.3.4, 2.2.3.5 | | | | | | | |
| Зорилт 2.1 Бүх насны иргэдийг боловсролын үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамруулах; | | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээ тус бүрийн дундаж хувь | 100% | 100% | Бүх насны иргэдийг боловсролын үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамруулах зорилтын хүрээнд 3 арга хэмжээ төлөвлөж 2024-2025 оны хичээлийн жилд 67 суралцагч хамрагдаж байна. | 83 |
| 13 | Арга хэмжээ № 2.1.1 Боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, бага, суурь, боловсрол эзэмших танхимын болон хувилбарт сургалт зохион байгуулах ажлыг | Батлагдсан төсвийн хүрээнд | Боловсрол эзэмшсэн иргэдийн тоо | Бага - 10<br>Суурь - 30 | Бага-2<br><br>Суурь-13 | Аймгийн хэмжээний 13 суманд Насан туршийн суралцахуйн 14 багш Боловсрол нөхөн олгох сургалтыг танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулан ажиллаж байна. БШУ-ны сайдын А/88 дугаар тушаалын хавсралт "Боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөр"-ийн дагуу 2024-2025 оны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгдсэн удирдлагаар хангах; | | | | | бага суурь боловсрол нөхөн олгох сургалтад 67 суралцагч хамрагдаж байна. Бага боловсролд - 2, суурь боловсрол - 13 иргэн эзэмшинэ. | |
| 14 | Арга хэмжээ № 2.1.2 Амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нэгж тус бүр дээр чанартай зохион байгуулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Бичиг үсгийн боловсролын түвшин ахисан иргэдийн тоо | 19 | - | Бичиг үсэг үл мэдэгч насанд хүрэгчдийг бичиг үсэгт тайлах, бичиг үсэгт тайлагдалтын түвшинг нэмэгдүүлэх, Бичиг үсэг бага мэдэгчдийн унших, бичих, тооцоолох мэдлэг чадварыг дээшлүүлэх замаар мэдлэг чадварын түвшинг ахиулах сургалтыг насан туршийн боловсролын 13 суманд зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллав. 2025 оны 1-р улиралд нийт 7 иргэн хамрагдаж, шинээр 2 иргэн бичиг үсэг тайлагдаж, өмнөх түвшингээ 5 иргэн ахиулсан байна. | 100 |
| 15 | Арга хэмжээ: № 2.1.3. Сургуулийн гадна байгаа 0-18 насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг судалгаанд үндэслэн боловсролын үйлчилгээнд шинээр хамруулах, насан туршдаа суралцах, нийгэмшүүлэх үйл явцад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх; | Батлагдсан төсвийн хүрээнд | Боловсролын үйлчилгээнд шинээр хамруулсан хүүхдийн тоо | 13 | 18 | Сургуулийн гадна байгаа 0-18 насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг судалгааг шинэчлэн гаргаж байгаа бөгөөд 4-р сараас боловсролын үйлчилгээнд хамруулахаар төлөвлөөд байна. | 50 |
| Зорилт 2.2 Насан туршийн боловсрол олгох үндсэн 5 чиглэлийн хүрээнд сургалт үйл ажиллагаа зохион байгуулах, иргэд ажил амьдралын орчинд суралцах шаардлагатай ур чадвар эзэмших, хөгжих суралцахуйг дэмжих; | | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээ тус бүрийн дундаж хувь. | 98% | 98% | Насан туршийн боловсрол олгох үндсэн 5 чиглэлийн хүрээнд 5 арга хэмжээ төлөвлөж 29 сургалт зохион байгуулж 1003, нөлөөллийн арга хэмжээ давхардсан тоогоор 1100 иргэн хамрагдсан байна. | 92,5 |
| 16 | Арга хэмжээ №2.2.1. | 1 сая | Сургалтын тоо | 133 | 140 | Насан туршийн суралцахуйн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Насан туршийн суралцахуйн үндсэн агуулгын хүрээнд иргэдийн болон төрийн албан хаагчдын боловсролыг дэмжих захиалгат болон бусад сургалт, нөлөөллийн аян, арга хэмжээг зохион байгуулах; | | Хамрагдсан иргэдийн тоо | 4529 | 5200 | төв нь төрийн болон төрийн бус 11 байгууллагатай хамтран 13 сумын Насан туршийн суралцахуйн нэгжээр дамжуулан орон нутаг, иргэдийн онцлог ялгаатай хэрэгцээнд тохирсон насан туршийн суралцахуйн сургалт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан ажилласан бөгөөд 2025 оны 1 дүгээр улиралд нийт 19 удаагийн сургалтад иргэн, 355 иргэдийг хамруулан ажилласан байна. | |
| 17 | Арга хэмжээ №2.2.2. Санхүүгийн боловсролын агуулгын хүрээнд иргэдийн мэдлэг, ур чадварын нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах / Хуримтлалын аян, Дэлхийн мөнгөний 7 хоног / | Батлагдсан төсвийн хүрээнд | Сургалтын тоо Хамрагдсан иргэдийн тоо | 26<br><br>370 | 26<br><br>400 | “МӨНГӨНИЙ 7 ХОНОГ 2025” аяны хүрээнд Монгол банктай хамтран Мөнххаан сумын ЕБС 8,9-р 68 суралцагчдад “Халаасны мөнгөний зөв хэрэглээ”, “Хурамтлал” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан. | 70 |
| 18 | Арга хэмжээ №2.2.3. Тогтвортой хөгжлийн боловсролын агуулгын хүрээнд сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, нэгжийн багш нарыг удирдлагаар хангах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээ тус бүрийн дундаж хувь | 31<br><br>316 | 45<br><br>501 | Дэлхийн усны өдрийг угтан 7 сумын Насан туршийн суралцахуйн нэгжээр дамжуулан зурагт хуудас-13 бэлтгэн давхардсан тоогоор 1100 орчим иргэдэд хүрсэн байна. Усны зохист хэрэглээ, Эртэч сурагч сэдэвт 2 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж нийт 96 суралцагчдыг танхимаар хамруулав.<br><br>Дөрвөлж ОНӨҮГ-аас зохион байгуулсан “Ус хөгжлийн түлхүүр” сэдэвт эссэ бичлэгийн уралдаанд НТСТ-ын сургалтын менежер П.Уянга оролцож дэд байр эзэлсэн. | 100 |
| 19 | Арга хэмжээ №2.2.4. | Батлагдсан | Сургалтын тоо | 13 | 13 | Иргэдийн эрх зүйн боловсролыг | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сургалт үйл ажиллагаа зохион байгуулах, нэгжийн багш нарыг арга зүйн удирдлагаар хангах; | төсвийн хүрээнд | Хамрагдсан иргэдийн тоо | 290 | 350 | дээшлүүлэх сургалт үйл ажиллагаа зохион байгуулах 4,5-р сарuудад зохион байгуулахаар төлөвлөөд байна. | |
| 20 | Арга хэмжээ №2.2.5. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа зохион байгуулах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээ тус бүрийн дундаж хувь | 2<br>800 | 5<br>1000 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг 6 сумын Насан туршийн суралцахуйн нэгжээр дамжуулан зохион байгуулж нийт 484 суралцагчийг хамруулав. | 100 |
| Зорилт 2.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр төрөөс барьж буй бодлогыг хяналтдаа авч, хэрэгжилтийг хангах; | | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээ тус бүрийн дундаж хувь | 96% | 97% | Хүүхэд хамгааллын чиглэлээр төрөөс барьж буй бодлогыг хяналтдаа авч, хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд 2 арга хэмжээ төлөвлөж, Англи хэлний “Нэг мөрөөдөл” хөтөлбөрийг хэрэгжүүлж ODxBarun-Urt” Англи хэл дээр илтгэх арга хэмжээг БСГ-тай хамтран зохион байгуулж 200 гаруй хүүхэд хамрагдаж 6 суралцагч илтгэл тавьсан. Мөн 11 сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж 92 суралцагч эцэг эх, асран хамгаалагчид хамрагдсан. | 75 |
| 21 | Арга хэмжээ №2.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх асран хамгаалагчдад зориулсан "Тэгш боломжийг хамтдаа" өдөрлөг арга хэмжээ зохион байгуулах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Үйл ажиллагааны тоо<br>Хамрагдсан иргэдийн тоо | 0 | 3<br>40 | “Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудал хүүхэдтэй ажиллах арга зүй”, Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүй ба эцэг эх асран хамгаалагчдад өгөх зөвлөмж сэдэвт сургалтуудыг “Итгэл сэтгэлийн ертөнц “ТББ хамтран зохион байгууллаа. Сургалтад 12 иргэн хамрагдлаа. | 80 |
| 22 | Арга хэмжээ №2.3.2. Хүүхдийн хүмүүжил, хөгжил хамгааллын чиглэлээр сургууль, олон нийтийн | Батлагдсан төсвийн хүрээнд | Үйл ажиллагааны тоо<br>Хамрагдсан иргэдийн тоо | 2<br>300 | 3<br>350 | Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн чиглэлээр Бэлгийн боловсролын цогц агуулгын хүрээнд нэгжийн багш нараар дамжуулан: | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагатай хамтран сурагчид болон эцэг эх асран хамгаалагчид харгалзан дэмжигчдэд зориулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах; | | | | | • “Дотно харилцаа ба хүний эрх”<br>• “Өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэнд”<br>• Бие организмд гарах өөрчлөлтүүд тэдгээрийг даван туулах арга<br>• Сарын тэмдгийн мөчлөг ба ариун цэврийн сахилга бат<br><br>Сэдвүүдээр 8 сумын НТС нэгжээр дамжуулан сургуулийн өсвөр насны охид, хөвгүүдийн дунд сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. Дэлгэцийн донтолт сэдвээр 8 зурагт хуудас хийж цахим группүүдээр түгээн дэлгэрүүлээд байна.<br><br>ЕБС-ийн суралцагчдад зориулсан Англи хэлний “Нэг мөрөөдөл” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрт 12-р ангийн 15 сурагч хамрагдан 7 хоногт 3 удаагийн сургалтад хамрагдаж байна. Хөтөлбөрийг Аймгийн БСГ болон Англи хэлний мэргэжилтэн Марта Тэйлор нартай хамтран зохион байгуулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зориулсан “ODxBarun-Urt” Англи хэл дээр илтгэх арга хэмжээг БСГ-тай хамтран зохион байгуулж 200 гаруй хүүхэд хамрагдаж 6 суралцагч илтгэл тавьсан. | |
| ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |
| Зорилт 3.1. Насан туршийн суралцахуйн багш ажилтан, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, ур чадвар, | | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээ тус бүрийн дундаж хувь | 98% | 99% | Насан туршийн суралцахуйн багш ажилтан, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, ур чадвар, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, арга | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх; | | | | | | зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилтын хүрээнд сургалт үйл ажиллагаануудыг 4-р сараас эхлэхээр төлөвлөөд байна. | |
| 23 | Арга хэмжээ №3.1.1. Багш чадавхжуулах үндэсний бүсийн орон нутгийн, ажлын байрны танхимын болон цахим сургалтуудад хамруулах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Сургалтын тоо<br>Хамрагдсан албан хаагчдын тоо | 34<br><br>20 | 35<br><br>20 | HWPL олон улсын энх тайвны байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж багш нарт мэдээлэл хүргэж ажиллаж байна.<br><br>МУБИС, Боловсрол судлалын сургуулиас эрхлэн гаргасан “Насанд хүрсэн суралцагч” номын нээлтэд оролцож төвийн багш ажилтнуудад номын танилцуулгыг хийж түгээн дэлгэрүүлсэн.<br><br>МУБИС-ийн Насан туршийн боловсрол, зайн сургалтын тэнхимээс санаачлан Боловсролын Яам, Боловсролын ерөнхий газар, ҮБХИС хамтран зохион байгуулж буй “Насан туршийн боловсрол 2.0” Олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцож НТСТ-ийн болон нэгжийн багш нарт түгээн дэлгэрүүлэлт хийсэн.<br><br>Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн хамт олон зуун жилийн ойг тохиолдуулан “Гавьяатуудаасаа суралцъя” уриан дор аймгийнхаа 23 гавьяат багшийг урьж боловсролын салбарын нийт 300 гаруй багш ажилтнуудад арга зүйн туршлагаа хуваалцсан.<br><br>“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох төсөл”-ийн багш бэлтгэх сургалтад Насан туршийн суралцахуйн нэгжийн багш нарыг | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны 4-р сарын 3,4-ны өдрүүдэд хамруулахаар төлөвлөөд байна. | |
| 24 | Арга хэмжээ №3.1.2. Багш, удирдах ажилтны мэдээлэл холбооны технологи ашиглах чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Сургалтын тоо Хамрагдсан албан хаагчдын тоо | 3<br>18 | 2<br>22 | “AI ашиглан” видео контент, зурагт хуудас бэлтгэх багш чадавхжуулах сургалтыг И монголиа академитай хамтран зохион байгуулахаар төлөвлөж байна. /2025.04.05/ | 30 |
| 25 | Арга хэмжээ №3.1.3. “Насан туршийн суралцахуй” мэргэжлийн онолын анхдугаар уралдаан зохион байгуулах; | 500.0 мян төгрөг | Хамрагдсан багшийн хувь | 0 | 100% | Хугацаа болоогүй. | - |
| 26 | Арга хэмжээ №3.1.4. Насан туршийн суралцахуйн багш, ажилтнуудыг төрийн албаны болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн өрсөлдөөнт, ил тод, чадахуйн зарчмаар сонгон шалгаруулах ; | Төсөв шаардагдахгүй | Хүний нөөц бүрдүүлэлтийн хувь | 94.4% | 100% | Сүхбаатар аймгийн Насан туршийн суралцахуйн төвд 2025 оны эхний улирлын байдлаар ажлын байрны сул орон тоо байхгүй болно. | 100 |
| 27 | Арга хэмжээ №3.1.5. НТСТ-ийн багш ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх; | Төсвийн хүрээнд | Гүйцэтгэлийн үнэлгээний хувиар | 95% | 98% | 3 зорилго 7 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Хөнгөлөлт, тэтгэлэг, нөхөн олговор, тусламж дэмжлэгийг дотоод журамд заасны дагуу олгодог.<br>Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг хагас, бүтэн жилээр үнэлж дүгнэх, ур чадварын нэмэгдлийг хагас жилээр тооцон сар бүр олгодог.<br>Мэргэжлийн зэрэг олгох шаардлага хангасан  2 албан хаагч тэргүүлэх, 1 албан зөвлөх зэрэг горилон материалаа бүрдүүлж холбогдох байгууллагат уламжлахад бэлэн болсон. | 60 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Биеийн тамир спортын хамтлаг, эцэг эхийн зөвлөлийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллаж байна. Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тодорхой цагт хийж хэвшүүлсэн. | |
| Зорилт 3.2. Салбар дундын түншлэлийг хөгжүүлэх, түншлэгч байгууллагууд төрийн болон төрийн бус байгууллага, салбар холбоодтой хамтын ажиллагааг өргөжүүлэх; | | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээ тус бүрийн дундаж хувь. | 100% | 100% | Аймгийн ахмадын хороо, 13 сумдын ахмадын хорооны дарга, тэргүүлэгчдэд 2025 оны үйл ажиллагааны чиглэл хамтран ажиллах боломжуудын талаар мэдээлэл өглөө. Мөн гадаад улс орнуудад ахмадууд хэрхэн хамтран ажилладаг, ямар төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг талаар туршлага мэдээллийг хуваалцлаа. “Суралцагч хот”, “Цахимаар нэгдье” хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллахаар болов. Сүхбаатар аймаг дах Монгол банкны салбартай хамтран Санхүүгийн боловсрол аян, Дарьганга сумын Байгалийн цогцолборт газартай хамтран “Хамтдаа хамгаалсан - 20 жил, чуулганд сургалт, үйл ажиллагаа зохион байгуулсан. | 40 |
| 28 | Арга хэмжээ №3.2.1. Гадаад улсад насан туршийн суралцахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудаас туршлага судлах / цахим болон танхимын хэлбэрээр МУБИС-НТСТ / | Батлагдсан төсвийн хүрээнд | Хамтран ажилласан байгууллагын тоо | 0 | 1 | МУБИС – Насан туршийн боловсролын тэнхимтэй холбогдон гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй Насан туршийн байгууллагатай цахимаар туршлага судлахаар төлөвлөөд байна. | 30 |
| 29 | Арга хэмжээ №3.2.2. Иргэдийн насан туршдаа суралцахуйн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх,сурталчлах "Насан туршдаа суралцацгаая- Тантай | Батлагдсан төсвийн хүрээнд | Зохион байгуулсан сумын тоо<br>Хамрагдсан иргэдийн тоо | 4<br>315 | 5<br>350 | Монгол банктай хамтран “Санхүүгийн боловсрол” аяны хүрээнд “Насан туршдаа суралцацгаая – Тантай хамт” аян 4 дүгээр сард Баяндэлгэр суманд зохион байгуулахаар төлөвлөж байна. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамт " аян зохион байгуулах; | | | | | | |
| 30 | Арга хэмжээ №3.2.3. Иргэдийн насан туршдаа суралцахуйг дэмжих, "Суралцагч аймаг - 3.7.3" "Суралцагч хот" уралдааныг зохион байгуулах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Хамрагдсан байгууллагын тоо | 10 | 25 | “Суралцагч хот” хөтөлбөр, ЮНЕСКО-гийн Суралцагч хотуудын дэлхийн сүлжээнд нэгдэхийн давуу тал сэдвээр аймгийн ИТХ дарга болон Засаг дарга бусад удирдлагууд, мөн Баруун-Урт сумын ЗДТГ-ын хамт олонд мэдээлэл өгч Аймгийн ИТХ, Баруун-Урт сумын ЗДТГ-тай хамтран “Суралцагч хот” хөтөлбөр хэрэгжүүлэхээр болсон. Хөтөлбөрийн ажлын хэсэг байгуулагдаж хөтөлбөр боловсруулах түвшинд явж байна. | 70 |
| 31 | Арга хэмжээ №3.2.4. МБС-тай хамтран тогооч, үсчин, гоо сайханч, барилгын засал чимэглэлч, мужаан, авто засварчин мэргэжлүүдээр “Мэргэжил сурталчлах өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулах; | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээний тоо<br>Хамрагдсан иргэдийн тоо | 5<br>1000 | 6<br>1100 | Хугацаа болоогүй. | - |
| Зорилт 3.3. Иргэдийн насан туршдаа суралцахуйн хэрэгцээг тодорхойлж, хүн бүрд орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах, боловсрол эзэмших тэгш хүртээмжтэй сургалтын контент, ур чадвар, чадамжийг дэмжсэн сургалт нөлөөллийн үйл ажиллагааг холбогдох талуудтай хамтран хэрэгжүүлнэ; | | Төсөв шаардахгүй | Арга хэмжээ тус бүрийн дундаж хувь | 100% | 100% | Зорилтын хүрээнд Сургууль завсардалтын болон Бүх нийтийн англи хэлний хөтөлбөр хэрэгжүүлэх судалгаануудыг авч байна. Мөн Цахимаар нэгдье хөтөлбөрийн сургалтыг 3 байгууллагат зохион байгуулж 37 ажилтан албан хаагчид хамрагдсан байна. | 40 |
| 32 | Арга хэмжээ №3.3.1. 2023-2024 оны хичээлийн жилд Аймгийн хэмжээнд сургууль завсардсан | Төсөв шаардахгүй | Судалгааны тоо | 0 | 1 | Сургууль завсардалтын судалгааг авч байна. | 60 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэдийн судалгааг гаргах; | | | | | | |
| 33 | Арга хэмжээ №3.3.2. Иргэдийн насан туршийн суралцахуйд дэмжлэг үзүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг тандах судалгаа, оношилгоо, хэрэглэгчийн үнэлгээний ажлыг багш, ажилтан, иргэд, олон нийтийн оролцоотой зохион байгуулах; | Батлагдсан төвсийн хүрээнд | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо Судалгаанд хамрагдсан нэгжийн тоо | 13<br>761 | 13<br>800 | Аймгийн Засаг даргын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд бүх нийтийн Англи хэлний хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдуулан Аймгийн хэмжээнд нийт иргэдийн сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг авч байна.<br>ЗГХХГ-аас Улсын Үнэлгээний Чадавхын Индекс (INCE) тогтоох судалгааны асуумжийг хэрхэн бөглөх заавар, зөвлөмж өгөх, тус индексийн талаар мэдээлэл өгөх онлайн сургалтад хамрагдсан. | 70 |
| 34 | Арга хэмжээ №3.3.3. Иргэдийн мэдээлэл харилцаа технологийн ур чадварыг дээшлүүлэх "Цахимаар нэгдье" хөтөлбөрийн хүрээнд сургалт үйл ажиллагаа зохион байгуулах; | Батлагдсан төвсийн хүрээнд | Сургалтын тоо Хамрагдсан иргэдийн тоо | 28<br>477 | 35<br>550 | Баруун урт сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг, Шуудан холбооны газар, Авто тээврийн газар зэрэг байгууллагын 37 албан хаагчдад сургалт үйл ажиллагаа зохион байгуулсан. | 70 |
| 35 | Арга хэмжээ №3.3.4 Насан туршийн суралцахуйн тухай ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, таниулах, утга агуулга бүхий цахим зурагт хуудас, богино хэмжээний видеог AI ашиглан бэлтгэх уралдаан зохион байгуулах; | Батлагдсан төвсийн хүрээнд | Оролцсон багшийн тоо Зурагт хуудасны тоо Видеоны тоо | 0 | 14<br>43<br>15 | Хугацаа болоогүй. | - |
| 36 | Арга хэмжээ №3.3.5 Нийгэм, эдийн засгийн хувьд ялгаатай болон малчин өрхийн хүүхэд залуучуудын боловсролыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх; | Батлагдсан төвсийн хүрээнд | Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо | 0<br>0 | 13<br>60 | Хугацаа болоогүй. | - |

*Төлөвлөгөө тайлагнасан:*

............................ ......................... /................................./

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................